



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/857

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 а, Монгол улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн туршлага судлах, чадавхжуулах сургалтын арга хэмжээний зардалд 25.0 сая төгрөг /хорин таван сая/-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний санхүүжилтийн 25.0 сая төгрөг /хорин таван сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3 дугаар хуралдааны "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 3/03 дугаартай тогтоолын 6 дугаар хавсралтын 5 дугаар заалтын 5.4-д тусгагдсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийг чадавхижуулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ